



ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХК

**2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС  
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАН**

Дархан-Уул

2021 он

## Агуулга

Агуулга .....	1
Нэг. Компанийн товч танилцуулга .....	2
1.1. Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйл .....	2
1.2. Зохион байгуулалтын бүтэц, хүний нөөц .....	3
Хоёр. Хангах үйл ажиллагаа .....	5
2.1. Худалдан авсан цахилгаан эрчим хүч.....	6
2.2. Борлуулсан цахилгаан эрчим хүч .....	7
2.3. Цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдал .....	8
2.4. Цахилгаан эрчим хүчний орлого .....	9
2.5. Цахилгаан эрчим хүчний авлага .....	9
2.8. Эрчим хүч хэмнэлт .....	13
Гурав. Түгээх үйл ажиллагааны чиглэлээр .....	18
3.1. Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтын ажил .....	18
3.2. Урсгал засварын ажил.....	22
3.3. Эргүүл үзлэг.....	24
3.4. Тасралт .....	28
3.5.Захиалгат тасралт.....	36
3.6. Гэмтэл .....	37
3.7. Дуудлага барагдуулалт .....	38
3.8. Горим ажиллагаа, ачааллын өсөлт .....	40
3.9. Зураг төслийн ажил.....	43
3.10.Мэдээллийн сан бүрдүүлэх ажил .....	48
3.11.Техникийн нөхцөл олголт .....	54
Дөрөв: ХАБЭА-н ажлын зохион байгуулалт, хяналт шалгалт .....	59
4.1. ISO45001:2018 ХЭМАБ-ЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО ХЭРЭГЖИЛТ .....	59
4.2. ХАБЭА-н дасгал сургууль явуулсан талаар .....	62
4.3.Мэргэшлийн ээлжит шалгалтын талаар .....	63
4.4.Аюулыг мэдээлэх хуудас.....	64
4.5. Технологийн зөрчлийг судалсан талаар .....	65
4.6. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн хангалтыг сайжруулах талаар .....	65
4.7. Хөдөлмөр хамгааллын зардлын зарцуулалтын талаар .....	66
4.8.Тоног төхөөрөмж, дамжлагуудын аа-ны ерөнхий шаардлага хангалт .....	66
Тав. Хяналт шалгалт.....	68
5.1. Өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлт .....	68
5.2. ЦЭХ-ний хөнгөлөлттэй тарифт хэрэглэгчдэд тарифт хамрагдсан байдал.....	69
5.3. Төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус .....	71
5.4.Хамгаалалтын зурвасын талаар.....	72
Зургаа. Гамшиг, байгаль орчин, ГАУС, сургалт.....	74
6.1. Гамшгаас хамгаалах чиглэлээр .....	74
6.2.Байгаль орчныг хамгаалах чиглэлээр .....	75
6.3.ГАУС .....	75
6.4.Ариутгал халдваргүйжүүлэлт .....	76
6.5.Сургалтын ажлын талаар .....	77

## Нэг. Компанийн товч танилцуулга

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн дагуу Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК нь Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгуудын 26 сумын 74000 км<sup>2</sup> нутаг дэвсгэрт орших 4435 аж ахуйн нэгж, 44491 айл өрх, нийт 48926 хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүч түгээх, хангах үйл ажиллагааг Монгол Улсын Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Улсын Стандартчилал Хэмжилзүйн Төвөөс олгосон 9 тусгай зөвшөөрөл, лицензийн дагуу явуулж байна. Үүнд:

- 1) Цахилгаан түгээх
- 2) Цахилгаанаар зохицуулалттай хангах
- 3) 0.4-220 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар
- 4) Туршилт тохируулгын ажил үйлчилгээ /2-догч коммутацийн ажлууд болон хэмжилт туршилт тохируулгын бүх төрлийн ажлууд/
- 5) Бусад дагалдах ажил үйлчилгээ /өрлөг дулаалга бэхэлгээ болон тулгуур хийц хэсгийн үйлдвэрлэлт, нийлүүлэлт/
- 6) 0.1-100МВт-ын эрчим хүчний эх үүсвэрийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах
- 7) Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 110кВ-оос дээш
- 8) ЦЭХ-ний 1 ба 3 фазын тоолуурын шалгалт, тохируулга, суурилуулах
- 9) Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр барих



### 1.1. Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйл

Уриа - **ГЭРЛИЙН ХУРДААР ХӨГЖЛИЙГ ДЭМЖИНЭ...**

Алсын хараа - Эрчим хүчийг дэвшилтэт технологиор хэрэглэгчдэд....

Эрхэм зорилго - Чадварлаг хүний нөөцөд тулгуурлан аюулгүй ажиллагааг эрхэмлэж, дэвшилтэт технологийн нэвтрүүлэн, хэрэглэгчээ дээдэлсэн, салбартаа тэргүүлэгч үйлчилгээний байгууллага болно.

Үнэт зүйл - Дэвшилтэт технологи, Сэтгэл зүтгэл, Цогц чадамж, Төгөлдөршил, Сахилга бат, Хэрэглэгчийн итгэл, Компанийн засаглал

Тэргүүлэх чиглэл – Техник технологи, Хүний нөөц, Хөгжил, Өсөлт, Аюулгүй ажиллагаа, Хэрэглэгч

#### ҮНДСЭН ЗОРИЛТ

- 1) Дэлхийн жишигт хүрсэн техник, технологи, IT программ хангамжийг ашиглаж, хөгжүүлнэ.
- 2) Санал санаачлагатай, өөриймсөг, бүтээлч шийдэлтэй нэгдмэл чадварлаг сэтгэл зүтгэлтэй хамт олон байна.
- 3) Дэвшилтэт технологи, чадварлаг хүний нөөцтэй хэрэглэгчдийнхээ хүсэлт тэмүүллийг мэдэрдэг, өндөр бүтээмж цогц чадамжтай компани болно.
- 4) Бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд осол аюулгүй, түргэн шуурхай хүргэж, борлуулалтын орлого, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлнэ.
- 5) Аюул, эрсдэлийг илрүүлж, арилган аюул эрсдлээс сэргийлэх зөв дадал хэвшил эзэмшүүлж, осол зөрчилгүй ажиллана.


6) Харилцагч, хэрэглэгчдийн эрх ашгийг дээдэлж, харилцан итгэлцэл, хүндлэлийг бий болгон ажиллана.

7) Бид ирээдүй болон цаашдын хөгжил дэвшилд бодлогыг тодорхойлж, ажилтан албан хаагчийн эрх ашгийг дээдэлсэн, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлага ухамсарласан компани байна.

## 1.2. Зохион байгуулалтын бүтэц, хүний нөөц

ДСЦТС ХК нь 2021 оны эхний хагас жилд бодлого зохицуулалтын 5 хэлтэс, мэдээлэл технологи, шуурхай удирдлага, засвар туршилт, хэмжүүр тоолуур, тээвэр үйлчилгээний чиглэлээр ажиллах 5 алба, тоног төхөөрөмжийн ашиглалт борлуулалтын ажлыг эрхлэн гүйцэтгэх 4 салбар, 2 төвтэйгөөр 442 орон тоотой ажиллахаас нийт 433 ажилтан байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээтэй, мөн 5 ажилтан хөлсөөр ажиллах гэрээ байгуулан гэрээт ажилтнаар ажиллаж байна.

ДСЦТС ХК-ийн БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



- Компанийн 2021 оны хүний нөөцөд бүртгэлтэй байгаа 58 иргэний анкет болон компанийн ажилтнуудын боловсрол, ажилласан жил, туршлагыг харгалзан “Сул чөлөөтэй болон эзгүй орон тоонд ажилтан сонгон шалгаруулж ажилд авах журам”-ын дагуу Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 22 иргэнийг ажлын байраар ханган хүний нөөцийн нөхөн бүрдүүлэлтийг хийж ажиллалаа.
- Хүний нөөцийн програмд 2021 оны эхний хагас жилд шинээр ажилд орсон 22 ажилтнуудын анкет, ажлын байр өөрчлөгдсөн 10 ажилтан, ажлаас чөлөөлөгдсөн 11 ажилтаны , бусад дэлгэрэнгүй мэдээллийг оруулан баяжилтыг тухай бүрд нь хийн, програмаас шаардлагатай мэдээлэл, судалгаа, тайланг гарган ажиллаж байна.

№	Мэргэжил	Шинээр ажилд орсон				Хүүхэд асрах чөлөөтэйгөөс эргэн орсон
		Бүгд	Дээд сургуулиас	Тусгай дунд сургуулиас	Мэргэжлийн сургуулиас	
	Бүгд	26	16	4	2	4
1	Цахилгааны	17	8	4	1	4
2	Санхүүгийн	4	4			
3	Бусад	5	4		1	


**Хүний нөөцийн хөдөлгөөн /шинээр ажилд орсон/**

### Хүний нөөцийн хөдөлгөөн /ажлаас чөлөөлөгдсөн/


№	ШАЛТГААН	Тоо
1	Өөрийн хүсэлтээр /өөр ажилд орох-4, шилжилт -2, бусад -2/	8
2	Жирэмсний болон амаржсаны амралт , хүүхэд асрах чөлөө авсан	9
3	Өндөр насны тэтгэвэрт гарсан	3
	Нийт ажилчдын тоо	20

- Мөн 2021 оны эхний хагас жилд нийт 10 ажилтны ажлын байрыг өөрчилж ажилласан байна.
- 2021 оны эхний хагас жилд 243 ажилтан буюу 56.1 % ээлжийн амралтыг тооцон биеэр эдлүүлсэн.


### КОМПАНИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ




Нийт ажилтнуудын 28.4 хувийг эмэгтэйчүүд, 71.6 хувийг эрэгтэйчүүд тус тус эзэлж байна.



Нийт ажилтнуудаас компанид 41.1 хувь нь 0-5 жил, 30.0 хувь нь 6-10 жил , 11.1 хувь нь 11-15 жил, 6.0 хувь нь 16-20 жил, 11.8 хувь нь 21-ээс дээш жил тус тус ажилласан ажилтнууд эзэлж байна.



Нийт ажилтнуудаас 36 хүртэлх насныхан 257 ажилтан буюу 59,4 хувь, 36-аас дээш насныхан 176 ажилтан буюу 40,7 хувийг тус тус эзэлж байна. Компанийн ажилтнуудын дундаж наслалт 36.5 нас байна.



Одоогийн байдлаар компанийн хэмжээнд 171 удирдах болон ИТА /албан хаагч/, мэргэшлийн зэрэгтэй 15 ажилтан байдаг ба 48,7 % нь дээд боловсролтой ажилтнууд эзэлж байгаагаас 21 магистр зэрэгтэй ажилтнууд, 13 ажилтан гадаадад мэргэжил, боловсрол эзэмшсэн байна. Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн заалтын дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн 7 ажилтан байна.

## Хоёр. Хангах үйл ажиллагаа

### Хэрэглэгчийн бүтэц ангилал

Тус компани нь үйлчлэх хүрээний 26 сум, суурин газрын 49839 бүртгэлтэй хэрэглэгчдтэй цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулан ажиллаж байна.

Салбарууд	Хэрэглэгчийн ангилал						Бүгд	Эзлэх хувь
	ААНБ			Ахуй				
	ҮААНБ	Төсөв	Нийт	Гэр хороолол	Орон сууц	Нийт		
ББЗХ	135		135	4		4	139	0%
Жаргалант	318	43	361	3556	0	3556	3917	8%
Хөтөл	234	70	304	1726	1319	3045	3349	7%
Сүхбаатар	511	100	611	6367	1108	7475	8086	16%
ХҮТ	1979	200	2179	12171	13662	25833	28012	56%
Зүүнхараа	383	84	467	5371	498	5869	6336	13%
Нийт	3560	497	4057	29195	16587	45782	49839	100%



Ангилал	Дархан-Уул	Сэлэнгэ	Төв	Нийт
ААН	1,987	1,212	361	3,560
Төсөв	190	264	43	497
Орон сууц	13,362	3,221	4	16,587
Гэр хороолол	12,175	13,464	3,556	29,195
Дүн	27,714	18,161	3,964	49,839
хувь	55.61%	36.44%	7.95%	100%





## 2.1. Худалдан авсан цахилгаан эрчим хүч

2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр нэг худалдан авагчаас 243,5 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч худалдан авахаар төлөвлөснөөс 290,8 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч худалдан авч төлөвлөгөөнөөс 19.4%-р буюу 47,2 сая.кВт.цагаар өссөн байна. Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 33,6%-р буюу 73,0 сая.кВт.цагаар өссөн байна.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	Өссөн дүн	
2020 оны гүйцэтгэл	сая кВт цаг	35,412.8	32,277.0	30,685.6	37,314.6	39,612.8	42,416.0	217,718.8	
2021 оны анхны захиалга	сая кВт цаг	41,036.1	36,997.6	38,019.9	42,509.2	44,750.9	40,250.0	243,563.7	
2021 оны гүйцэтгэл	сая кВт цаг	47,025.3	40,946.6	50,373.4	50,599.1	50,267.2	51,593.5	290,805.1	
өмнөх оны гүйцэтгэлээс бууралт	биет	сая кВт цаг	11,612.5	8,669.6	19,687.8	13,284.5	10,654.4	9,177.5	73,086.3
	хувь	хувь	32.79%	26.86%	64.16%	35.60%	26.90%	21.64%	33.57%
	биет	сая кВт цаг	5,989.2	3,949.0	12,353.5	8,089.9	5,516.3	11,343.5	47,241.4



тухайн оны анхны захиалгаас	хувь	хувь	14.60%	10.67%	32.49%	19.03%	12.33%	28.18%	19.40%
-----------------------------	------	------	--------	--------	--------	--------	--------	--------	--------



Цахилгаан эрчим хүчний хэрэглээ өссөн шалтгаан нь ЭХЗХ-ны 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 481 дүгээр тогтоолын дагуу гэр хорооллын хоёр тарифт тоолууртай айл өрхийн шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифт 100%-ийн хөнгөлөлт үзүүлэх, МУЗГ-ын 211 дугаар тогтоол, ЭХС-ын 267,269 дүгээр тушаалаар батлагдсан “Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах түр журам”-ын дагуу зарим ААНБ, айл өрхийн ЦЭХ-ний төлбөрийг төрөөс хариуцсанаар айл өрх болон ААНБ-ийн хэрэглээ өссөн.

## 2.2. Борлуулсан цахилгаан эрчим хүч

Тайлант хугацаанд гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөөгөөр 252,8 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч борлуулалхаас 281,3 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч борлуулж өмнөх оны мөн үеэс 88,5 сая кВт.цагаар өсөж төлөвлөгөөний биелэлт 111,3 боллоо.





Борлуулалтын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 5 хувиар буюу 88,6 сая кВт цагаар өссөн байна.

Бүтэц	Хэмжих нэгж	2020 он	2021 он	Зөрүү	
				биет	хувь
ХАЦЭХ	мян.кВт.ц	217,718.82	290,805.14	73086.3	33.6%
Борлуулсан ЦЭХ	мян.кВт.ц	192748.7	281308.1	88559.4	45.9%
АХУЙ	Гэр хороолол	мян.кВт.ц	40696.2	21060.5	107.3%
	Орон сууц	мян.кВт.ц	25192.9	-2022.1	-7.4%
	Нийт	мян.кВт.ц	46850.7	65889.1	19038.4
ААН	мян.кВт.ц	78948.20	107152.5	28204.3	35.7%
УУААН	мян.кВт.ц	52029.4	93266.1	41236.7	79.3%
Төмөр зам	мян.кВт.ц	6031.7	5916.1	-115.6	-1.9%
Төсөв	мян.кВт.ц	8888.7	9193.3	304.6	3.4%
Нийт	мян.кВт.ц	192748.7	281417.1	88668.4	46.0%



### 2.3. Цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдал

Тайлант хугацаанд цахилгаан эрчим хүчний нийт алдагдал 3,27% буюу 9,4 сая.кВт.цаг болсон нь төлөвлөгөөт алдагдлыг /12,75%/ 9,48 нэгжээр буюу сая.кВт.цагаар буурсан, өмнөх оны гүйцэтгэлээс 1,38 нэгжээр буюу 21,5 сая.кВт.цагаар буурсан байна.



Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 8,2 пунктээр алдагдал буурсан байна.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	Өссөн дүн
2020 оны гүйцэтгэл	%	8.19%	4.61%	6.41%	24.34%	10.47%	12.69%	11.47%
2021 оны төлөвлөгөө	%	8.90%	5.80%	24.80%	13.20%	12.15%	11.94%	12.75%
2021 оны гүйцэтгэл	%	8.78%	2.25%	10.75%	6.38%	7.83%	-15.75%	3.27%
өмнөх оны гүйцэтгэлээс бууралт	%	0.6%	-2.4%	4.3%	-18.0%	-2.6%	-28.4%	-8.2%
тухайн оны төлөвлөгөөнөөс	%	-0.1%	-3.6%	-14.1%	-6.8%	-4.3%	-27.7%	-9.5%

Алдагдал өмнөх оны гүйцэтгэлээс 8,4 сая кВт цагаар буурсан байна.



## 2.4. Цахилгаан эрчим хүчний орлого

Гүйцэтгэлд ноогдох орлогын төлөвлөгөөний дагуу 41,5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 50,0 тэрбум төгрөгийн орлого цуглуулж гүйцэтгэлд ноогдох орлогын төлөвлөгөө 117% гүйцэтгэлтэй байна.



## 2.5. Цахилгаан эрчим хүчний авлага

ДСЦТС ХК нь 2021 оны 2-р улирлын гүйцэтгэлээр компанийн хэрэглэгчдээс авах цахилгаан эрчим хүчний авлага 5656.5 сая төгрөг болж оны эхний үлдэгдлээс 1602.3 сая төгрөгөөр өссөн байна. Авлагын үлдэгдлийг 2020 оны 2-р улирлын гүйцэтгэлийн үлдэгдэлтэй харьцуулахад 2714.0 сая төгрөгөөр буюу 51.2 хувиар авлага өссөн байна. Шалтгаан нь Ковид-19 цар тахалтай холбогдон үйлдвэр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа зогсож зарим ажиллаж байгаа ААН-үүд төлбөрөө төлөх боломжгүй гэсэн тайлбаруудыг ирүүлж байна.

		2013.06.30	2014.06.30	2015.06.30	2016.06.30	2017.06.30	2018.06.30	2019.06.30	2020.06.30	2021.06.30
1	ААН	1800.6	1772.7	2562.8	2990.9	674	1055.9	1207	650.7	4871.7
2	Төсөв	210.2	223.7	236.0	278.7	22.0	15.0	5.3	89.8	326.2
3	Ахуй	769.5	533.2	522.9	449.9	301.7	191.4	73.3	328.7	458.6
	<b>ЦЭХ-ний авлага</b>	<b>2780.3</b>	<b>2529.6</b>	<b>3321.7</b>	<b>3719.5</b>	<b>997.7</b>	<b>1262.3</b>	<b>1285.6</b>	<b>1069.2</b>	<b>5656.5</b>